БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2019/03




УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

# АГУУЛГА


| | Хуудасны дугаар |
|---|---|
| ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 2 |
| ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ | 4 |
| НИЙГМИЙН ДААТГАЛ | 6 |
| ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 8 |
| АМЬДАРЧ БУЙ ОРЧИН | 10 |
| ГЭМТ ХЭРЭГ | 14 |
| ДҮҮРГИЙН ТӨСӨВ | 17 |
| ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ | 20 |
| АЖ ҮЙЛДВЭР | 29 |

Хүснэгт 1. Баянгол дүүргийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлт, жил бүрийн 3 сард

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|
| Шинээр төрсөн хүүхэд | тоо | 1 298 | 1 122 ↓13.6 | 1 314 ↑17.1 | 1 187 ↓9.7 |
| Амаржсан эхийн тоо | Тоо | 1 286 | 1 111 ↓13.6 | 1 296 ↑16.7 | 1 176 ↓9.3 |
| Ажил хайгч иргэн, сарын эцэст | Хүн | 1 914 | 1 483 ↓22.5 | 552 ↓62.8 | 875 ↑58.5 |
| Халдварт өвчнөөр өвчилсөн хүн | Тоо | 1 899 | 817 ↓57.0 | 815 ↓0.2 | 620 ↓23.9 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | Тоо | 847 | 746 ↓11.9 | 1 448 ↑94.1 | 1 160 ↓19.9 |
| Валютын зах зээлийн ханш, сарын эцэст | 1US$=₮ | 2 048.9 | 2 447.5 ↑19.5 | 2 392.8 ↓2.2 | 2 631.5 ↑10.0 |
| Дүүргийн төсвийн орлого | Тэрбум төгрөг | 14.7 | 17.6 ↑19.7 | 19.9 ↑13.1 | 23.6 ↑18.6 |
| Дүүргийн төсвийн зарлага | Тэрбум төгрөг | 14.2 | 14.9 ↑4.9 | 16.9 ↑13.4 | 19.8 ↑17.2 |

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан ↑, ↓ зэрэг өөрчлөлтийн хувь;
↑, ↓ сөрөг өөрчлөлтийн хувь;
= тогтвортой

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

| Үзүүлэлт | Хэмжих Нэгж | 2018 оны III сард | | | | | 2019 оны III сард | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | |
| **Хүн амын нягтрал** /нэг кв км-т ногдох хүн/ | Тоо | 303 | Баянгол | 7 544 | Налайх | 54 | 308 | Баянгол | 7 726 | Налайх | 55 |
| | | | Чингэлтэй | 1 789 | Багануур | 47 | | Чингэлтэй | 1 769 | Багануур | 48 |
| | | | Сүхбаатар | 665 | Багахангай | 29 | | Сүхбаатар | 700 | Багахангай | 31 |
| **Ажилгүйчүүд** хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох | 0\000** | 83 | Багахангай | 546 | Сонгинохайрхан | 76 | 82 | Багахангай | 618 | Хан-Уул | 54 |
| | | | Багануур | 310 | Налайх | 65 | | Багануур | 132 | Налайх | 48 |
| | | | Сүхбаатар | 113 | Хан-Уул | 51 | | Баянзүрх | 131 | Сонгинохайрхан | 47 |
| **Нялхсын нас баралт** /амьд төрсөн 1000 хүүхдэд/ | 0\00* | 10 | Чингэлтэй | 14 | Багануур | 6 | 12 | Налайх | 19 | Багануур | 7 |
| | | | Сонгинохайрхан | 12 | Налайх | 5 | | Чингэлтэй | 16 | Хан-Уул | 5 |
| | | | Хан-Уул | 11 | Багахангай | - | | Баянзүрх | 13 | Багахангай | - |
| 10 000 хүн тутмаас **халдварт өвчнөөр өвчлөгсөд** | 0\000 | 41 | Баянзүрх | 54 | Хан-Уул | 35 | 24 | Баянзүрх | 44 | Сонгинохайрхан | 26 |
| | | | Сүхбаатар | 46 | Налайх | 34 | | Чингэлтэй | 35 | Багануур | 25 |
| | | | Багануур | 44 | Багахангай | 15 | | Хан-Уул | 34 | Багахангай | 5 |
| **Төсвийн орлого, зарлагын харьцаа** зарлага=100 | тоо | 118 | Сүхбаатар | 143 | Багануур | 13 | 87 | Сүхбаатар | 111 | Багануур | 11 |
| | | | Чингэлтэй | 105 | Налайх | 9 | | Чингэлтэй | 53 | Налайх | 10 |
| | | | Баянгол | 37 | Багахангай | 6 | | Хан-Уул | 47 | Багахангай | 6 |
| 18-аас дээш насны 10 000 хүнд ногдох **Гэмт хэрэг** | тоо | 83 | Сүхбаатар | 135 | Налайх | 55 | 71 | Сүхбаатар | 98 | Налайх | 45 |
| | | | Баянзүрх | 102 | Багахангай | 51 | | Чингэлтэй | 86 | Багануур | 28 |
| | | | Баянгол | 97 | Багануур | 42 | | Баянгол | 78 | Багахангай | 25 |

Тайлбар: * - промиль ** - продицмиль

## ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2019 оны 3 сард 875 болж, өмнөх оны мөн үеэс 323 хүнээр (58.5%) өссөн байна. Нийт бүртгэгдсэн ажилгүй иргэдийн 483 нь (55.2%) эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлгээр, хувь




Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 68 нь (7.8%) 15-24 насны, 393 нь (44.9%) 25-34 насны, 245 нь (28.0%) 35-44 насны, 131 нь (15.0%) 45-54 насны, 32 нь (3.7%) 55-59 насны, 6 нь (0.7%) 60-аас дээш насны хүмүүс байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 14 нь (1.6%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд үүнээс 7 нь (50%) эмэгтэйчүүд байна.

Баянгол дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 2019 оны 3 сард 288 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 46 иргэн ажилд зуучлагдан орж, 106 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Зураг 2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд




| | Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд | Ажилд зуучлагдан орсон иргэд |
|---|---|---|
| 2018- III | 223 | 55 |
| 2019- III | 288 | 46 |

2019 оны 3 сард 288 ажилгүй иргэн шинээр бүртгүүлснээс 21 нь (7.3%) сургууль төгсөөд ажилгүй байгаа, 11 нь (3.9%) шилжин суурьшсан, 214 нь (74.3%) ажлаас чөлөөлөгдсөн буюу халагдсан, 42 нь (14.5%) бусад шалтгаанаар ажил хайж байна.

Зураг 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар, 2019 оны эхний 3 сард



391 (44.7%) Бүрэн дунд

414 (47.3%) Дипломын болон бакалаврын дээд

36 (4.1%) Тусгай мэргэжлийн дунд

3 (0.4%) Бага

13 (1.4%) Техникийн болон мэргэжлийн анхан шат

11 (1.3%) Магистр, доктор

6 (0.7%) Суурь

1 (0.1%) Боловсролгүй

2019 оны 3 сарын эцэст бүртгэлтэй байгаа ажилгүй иргэдийн 44.7 хувийг бүрэн дунд, 47.3 хувийг дипломын болон бакалаврын дээд, 4.1 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.4 хувийг техникийн болон мэргэжлийн анхан шат, 1.3 хувийг магистр, доктор, 0.7 хувийг суурь, 0.4 хувийг бага боловсролтой, 0.1 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст, жил бүрийн 3 сард

| Үзүүлэлт | | 2018-III | | 2019-III | |
|---|---|---|---|---|---|
| | | Бүгд | Эмэгтэй | Бүгд | Эмэгтэй |
| Өмнөх сарын эцэст байсан ажилгүй иргэн | | 581 | 323 | 739 | 408 |
| Тухайн сард нэмэгдсэн ажилгүйчүүд | | 223 | 114 | 288 | 166 |
| Тухайн сард бүртгэлээс хасагдсан | | 252 | 138 | 152 | 91 |
| Үүнээс: ажилд зуучлагдсан | | 55 | - | 46 | 23 |
| Тухайн сарын эцэст байгаа ажил хайгч иргэн | | 552 | 299 | 875 | 483 |
| Үүнээс: Насны ангиллаар | 15-24 | 97 | 57 | 68 | 38 |
| | 25-34 | 200 | 113 | 393 | 214 |
| | 35-44 | 142 | 85 | 245 | 132 |
| | 45-59 | 110 | 43 | 163 | 97 |
| | 60+ | 3 | 1 | 6 | 2 |

Эх үүсвэр: БГД-ийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн мэдээ

## НИЙГМИЙН ДААТГАЛ

Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь 2019 оны эхний 3 сард нийгмийн даатгалын 5 төрлийн санд нийт 46.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 тэрбум төгрөгөөр (3.3%) өссөн байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөгөөр, жил бүрийн эхний 3 сард

| Үзүүлэлт | 2018 I-III | 2019 I-III | 2019 I-III / 2018 I-III |
|---|---|---|---|
| Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг | 44 839.3 | 46 283.7 | 103.2 |
| Үүнээс: | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 29 116.3 | 36 314.4 | 124.7 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 3 292.9 | 4 618.8 | 140.3 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 7 901.6 | 0 | 0 |
| ҮОМШӨ[1]-ний даатгалын сангийн | 3 696.4 | 4 216.2 | 114.1 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 832.1 | 1 134.3 | 136.3 |
| Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг | 34 668.1 | 39 530.6 | 114.0 |
| Үүнээс: | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 30 388.0 | 34 673.0 | 114.1 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 3 050.7 | 3 215.3 | 105.4 |
| ҮОМШӨ[1]-ний даатгалын сангийн | 342.2 | 351.1 | 102.6 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 887.2 | 1 291.2 | 145.5 |

Зураг 4. Даатгалын сангийн орлого




Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 78.6 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 9.1 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 9.9 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 2.4 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

[1]Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Зураг 5. Даатгалын сангийн зарлага




Нийгмийн даатгалын сангаас 2019 оны эхний 3 сард даатгуулагч иргэдэд 39.5 тэр бум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8 тэрбум төгрөгөөр (13.8%) өссөн байна. Нийт зардлын 87.7 хувийг тэтгэврийн, 0.9 хувийг ҮОМШӨ-ний, 8.1 хувийг тэтгэмжийн, 3.3 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангуудын зарлага, жил бүрийн эхний 3 сард

| Үзүүлэлт | Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо | | | Олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая төгрөгөөр | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2018 I-III | 2019 I-III | 2019 I-III / 2018 I-III | 2018 I-III | 2019 I-III | 2019 I-III / 2018 I-III |
| Тэтгэврийн даатгалын сан | 25 595 | 26 985 | 105.4 | 30 387.9 | 34 673.0 | 114.1 |
| Өндөр насны | 19 340 | 20 355 | 105.2 | 23 925.6 | 27 250.4 | 113.9 |
| Тахир дутуугийн | 3 746 | 4 006 | 106.9 | 2 903.6 | 3 390.5 | 116.8 |
| Тэжээгчээ алдсаны | 966 | 1 005 | 104.0 | 796.3 | 890.8 | 111.9 |
| Цэргийн тэтгэвэр | 1 543 | 1 619 | 104.9 | 2 762.4 | 3 141.3 | 113.7 |
| Тэтгэмжийн даатгалын сан | 6 107 | 5 875 | 96.2 | 3 050.7 | 3 215.3 | 105.4 |
| Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж | 4 299 | 4 096 | 95.3 | 589.3 | 592.9 | 100.6 |
| Жирэмсэн, амаржсаны тэтгэмж | 1 788 | 1 761 | 98.5 | 2 441.1 | 2 604.4 | 106.7 |
| Оршуулгын тэтгэмж | 20 | 18 | 90.0 | 20.3 | 18 | 88.7 |
| ҮОМШӨ-ний даатгалын сан | 263 | 233 | 88.6 | 342.1 | 351.0 | 102.6 |
| Тахир дутуугийн тэтгэмж | 199 | 184 | 92.5 | 280.5 | 289.1 | 103.1 |
| Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 27 | 29 | 107.4 | 37.0 | 47.3 | 127.8 |
| Тэтгэмж, төлбөр | 30 | 14 | 46.7 | 23.3 | 13.9 | 59.7 |
| ҮОМШӨ-ний сувилал | 7 | 6 | 85.7 | 1.3 | 0.7 | 53.8 |
| Ажилгүйдлийн даатгалын сан | 553 | 584 | 105.6 | 887.2 | 1 291.2 | 145.5 |
| Ажилгүйдлийн тэтгэмж | 553 | 584 | 105.6 | 887.2 | 1 291.2 | 145.5 |

*Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

# ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2019 оны эхний 3-р сарын байдлаар 1176 эх амаржиж, 1187 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 120-иор (9.3%), мэндэлсэн хүүхэд 127 хүүхдээр (9.7%) тус тус буурсан байна. Мөн энэ хугацаанд Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэгт 2600 иргэн хэвтэн эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 79 (3.0%) хүнээр буурсан байна.

Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний 3 сард

| Үзүүлэлт | 2017 I-III | 2018 I-III | 2019 I-III | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | хувь |
| Амаржсан эхийн тоо | 1 111 | 1 296 | 1 176 | -120 | 90.7 |
| Амьд төрсөн хүүхэд | 1 122 | 1 314 | 1 187 | -127 | 90.3 |
| Нас барсан хүн | 206 | 240 | 217 | -23 | 90.4 |
| Эхийн эндэгдэл | - | - | 1 | 1 | - |
| Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд | 6 | 10 | 10 | - | 100 |
| 1-5 настай хүүхдийн эндэгдэл | 2 | 1 | - | -1 | - |
| Амьгүй төрөлт | 6 | 3 | 3 | - | 100 |
| Гэрийн төрөлт | 1 | 2 | 4 | 2 | 2* |
| Хяналтгүй төрөлт | 4 | 3 | 4 | 1 | 133.3 |

*-дахин их

Баянгол дүүрэгт 2019 оны эхний 3 сард халдварт өвчний 620 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 195 (23.9%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 9.7 продицмилээр тус тус буурсан байна.

Зураг 6. Халдварт өвчин, сараар



Хүснэгт 7. Дүүрэгт гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний 3 сард

| Үзүүлэлт | 2017 I-III | 2018 I-III | 2019 I-III | 2019 I-III / 2018 I-III |
|---|---|---|---|---|
| Халдварт өвчин бүгд | 817 | 815 | 620 | 76.1 |
| Цочмог халдварт өвчин | 609 | 621 | 423 | 68.1 |
| Үүнээс: | | | | |
| Цусан суулга | 40 | 66 | 86 | 130.3 |
| Улаан эсэргэнэ | 67 | 48 | 17 | 35.4 |
| Менингококкт халдвар | - | - | 1 | - |
| Гепатит | 5 | 11 | 7 | 63.6 |
| Салхинцэцэг | 247 | 161 | 239 | 148.4 |
| Гахай хавдар | 3 | 1 | 2 | 2* |
| Сальмонеллёз | 2 | 5 | 2 | 40.0 |
| Бруцеллёз | 2 | - | - | - |
| Хүнсний гаралтай бактерт хордлого | - | 1 | 36 | 36.0* |
| Ёлом | 2 | 4 | 3 | 75.0 |
| Нярайн халдвар | - | - | 1 | 100.0 |
| Гар хөл амны өвчин | 193 | 91 | 29 | 31.9 |
| Хумхаа | - | 172 | - | - |
| Улаанууд | 1 | - | - | - |
| Энтервирүст цэврүүт фарингит | - | 4 | - | - |
| Эритема | 4 | 6 | - | - |
| Аскариаз | - | 1 | - | - |
| Энтеробиоз | - | 1 | - | - |
| Энтеровирүст халдвар | - | - | - | - |
| Арьсны халдварт өвчин (exanthema subitum) | 43 | 49 | - | - |
| БЗХӨ бүгд | 142 | 127 | 142 | 111.8 |
| Тэмбүү | 79 | 59 | 91 | 154.2 |
| Заг хүйтэн | 22 | 20 | 26 | 130.0 |
| Трихомониаз | 39 | 48 | 25 | 52.1 |
| Мөөгөнцөр | 2 | - | - | - |
| Шинээр илэрсэн сүрьеэ | 66 | 67 | 55 | 82.1 |

*дахин их

## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2019 оны 3 дугаар сард дунджаар -3.8$^{0}$C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -1.8$^{0}$C-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 11.2$^{0}$C, хамгийн хүйтэн хэм -14.7$^{0}$C, хур тунадасгүй, салхины үнэмлэхүй их хурд 15 метр секунд хүрч, шороон болон цасан шуургатай өдөр 4 бүртгэгдсэн байна.

Хүснэгт 8. Агаарын бохирдолт, мг/м$^{3}$, III сард[2]

| Бодисын нэр | | Стандарт хэмжээ | Хэмжил тийн тоо | Хамгийн их хэмжээ | Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо | Агаарт байсан дундаж хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| Хүхэрлэг хий | $SO_2$ | 0.050 | 438 | 0.138 | 43 | 0.026 |
| Азотын давхар исэл | $NO_2$ | 0.050 | 324 | 0.083 | 53 | 0.032 |
| Тоосжилт | $PM_{10}$ | 0.100 | 381 | 0.488 | 241 | 0.153 |
| | $PM_{2.5}$ | 0.050 | 246 | 0.172 | 130 | 0.062 |
| Нүүрстөрөгчийн дутуу исэл[3] | CO | 10.000 | 517 | 5.835 | - | 1.190 |
| Озон | $O_3$ | 0.100 | 528 | 0.079 | - | 0.027 |

2019 оны 3 дугаар сард хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Баруун 4 зам орчимд 1 удаа, I хороолол орчимд 13 удаа, Хар хорин зах орчимд 1 удаа, Толгойт орчимд 5 удаа, Зурагт орчимд 19 удаа, Баянхошуу орчимд 1 удаа, Амгалан орчимд 3 удаа, азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж I хороолол орчимд 16 удаа, XIII хороолол орчимд 24 удаа, Хар хорин зах орчимд 10 удаа, Зурагт орчимд 3 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Мишээл экспо төв орчимд 10 удаа, Баруун 4 зам орчимд 10 удаа, I хороолол орчимд 28 удаа, XIII хороолол орчимд 21 удаа, 32-ын тойрог орчимд 24 удаа, Хар хорин зах орчимд 26 удаа, Ургах наран хороолол орчимд 10 удаа, Хайлааст орчимд 18 удаа, Нисэх орчимд 30 удаа, Толгойт орчимд 26 удаа, Зурагт орчимд 26 удаа, Баянхошуу болон Амгалан орчимд тус бүр 30 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 7. Улаанбаатар[4] хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 15 харуулын дундаж, сараар, мг/м$^{3}$




[2] Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

[3] 8 цагийн дундаж

[4] Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдол хэмжих харуул цэг байхгүй.

Зураг 8. Улаанбаатар[3] хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 15 харуулын дундаж, сараар, мг/м³




Зураг 9. Улаанбаатар[3] хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, 15 харуулын дундаж, сараар, мг/м³




Зураг 10. Улаанбаатар[3] хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 15 харуулын дундаж, сараар, мг/м³



### *Туул голын усны бохирдол:*

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2019 оны 3 дугаар сарын 27, 28-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд амоны азот 67.9 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 63.3 дахин, эрдэс фосфор 22.1 дахин хүлцэх хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 9. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м$^3$, III сард[5]

| Үзүүлэлт | | Стандарт хэмжээ | "Туул-Налайх" харуул цэг | | "Туул-Сонгино доод" харуул цэг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэмжээ | Бодисын хэтрэлт | Хэмжээ | Бодисын хэтрэлт |
| Хүчилтөрөгч | $O_2$ | ≥6 | 5.21 | Хэвийн | 0.0 | - |
| Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | $БХХ_5$ | ≤ 3 | 3.3 | Хэвийн | 190 | 63.3 дахин |
| Нитритийн нэгдэл | $NO_2$ | ≤ 0.02 | 0.005 | Хэвийн | 0.002 | Хэвийн |
| Амоны азот | $NH_4$ | ≤0.5 | 0.04 | Хэвийн | 33.95 | 67.9 дахин |
| Эрдэс фосфор | P | ≤0.1 | 0.002 | Хэвийн | 2.212 | 22.1 |

### *Байгаль орчны зөрчил:*

Нийслэлийн хэмжээнд 2019 оны эхний 3 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 110 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 70.9 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 24.5 хувийг газрын зөрчил, 1.0 хувийг ан агнууртай холбоотой зөрчил, 1.8 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зөрчил, 1.8 хувийг бусад төрлийн зөрчил тус тус эзэлж байна. 2019 оны эхний 3 сард илрүүлсэн нийт зөрчилд 40.2 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Хүснэгт 10. Байгаль орчны зөрчил, төрлөөр, эхний III сард

| Илрүүлсэн зөрчил, төрлөөр | 2018 III | | | 2019 III | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Үзлэг шалгалт | Илрүүлсэн зөрчил | Торгууль (сая төгрөг) | Үзлэг шалгалт | Илрүүлсэн зөрчил | Торгууль (сая төгрөг) |
| Бүгд | 88 | 20 | 20.1 | 125 | 110 | 40.2 |
| Ой | 2 | - | - | | | |
| Ан, амьтан | 1 | - | - | 2 | 1 | 1.2 |
| Газрын | 8 | 7 | 10.5 | 27 | 27 | 13.59 |
| Ус | - | - | - | | | |
| Ургамал, хөрсний бохирдол | 1 | 1 | - | | | |
| Агаар, химийн хорт бодис | 23 | 5 | 1.6 | | | |
| Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай | 49 | 3 | - | 78 | 78 | 24.05 |
| Геодези зураг зүй, кадастр | - | - | - | | | |
| Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ | 4 | 4 | 8.0 | 2 | 2 | 0.8 |
| Бусад | - | - | - | 16 | 2 | 0.6 |

[5] Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

Хүснэгт 11. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м$^3$, III сард

| Агаарын бохирдлын үзүүлэлт | | Мишээл-Экспо төв | Баруун дөрвөн зам | I хороолол | XIII хороолол | 32-ын тойрог | Офицеруу-дын ордон | Хархорин зах | Ургах наран хороолол | Нисэх | Толгойт | Зурагт | Амгалан | Дамба-даржаа | Баянхошуу | Хайлааст |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүхэрлэг хий $SO_2$ | Дундаж | 0.019 | 0.028 | 0.050 | 0.023 | 0.022 | 0.026 | 0.020 | 0.014 | 0.016 | 0.036 | 0.057 | 0.022 | 0.021 | 0.025 | 0.018 |
| | Хамгийн их | 0.044 | 0.053 | 0.138 | 0.050 | 0.043 | 0.049 | 0.052 | 0.033 | 0.026 | 0.066 | 0.114 | 0.059 | 0.042 | 0.061 | 0.044 |
| | ХХХ*-с давсан хувь | 0.0 | 3.0 | 42.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 3.0 | 0.0 | 0.0 | 16.0 | 61.0 | 10.0 | 0.0 | 3.0 | 0.0 |
| | Хэмжилтийн тоо | 24 | 30 | 31 | 31 | 26 | 26 | 29 | 31 | 31 | 31 | 31 | 30 | 27 | 30 | 30 |
| Азотын давхар исэл $NO_2$ | Дундаж | - | - | 0.046 | 0.063 | - | 0.019 | 0.044 | 0.027 | 0.021 | 0.022 | 0.039 | 0.030 | 0.021 | - | 0.020 |
| | Хамгийн их | - | - | 0.074 | 0.083 | - | 0.037 | 0.072 | 0.046 | 0.031 | 0.032 | 0.058 | 0.043 | 0.041 | - | 0.044 |
| | ХХХ*-с давсан хувь | - | - | 52.0 | 77.0 | - | 0.0 | 34.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 10.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 |
| | Хэмжилтийн тоо | - | - | 31 | 31 | - | 31 | 29 | 31 | 31 | 31 | 31 | 20 | 27 | - | 31 |
| Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO** | Дундаж | - | 1.666 | 2.048 | 0.998 | 1.203 | - | 0.836 | 0.390 | - | - | - | - | - | - | - |
| | Хамгийн их | - | 4.961 | 5.835 | 2.254 | 5.014 | - | 3.129 | 1.140 | - | - | - | - | - | - | - |
| | ХХХ*-с давсан хувь | - | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 | 0.0 | - | - | - | - | - | - | - |
| | Хэмжилтийн тоо | - | 91 | 93 | 72 | 79 | - | 89 | 93 | - | - | - | - | - | - | - |
| Тоос $PM_{10}$ | Дундаж | 0.092 | 0.088 | 0.172 | 0.123 | 0.153 | - | 0.162 | 0.093 | 0.192 | 0.136 | 0.152 | 0.178 | - | 0.253 | 0.200 |
| | Хамгийн их | 0.134 | 0.170 | 0.269 | 0.203 | 0.232 | - | 0.306 | 0.169 | 0.271 | 0.245 | 0.264 | 0.295 | - | 0.488 | 0.319 |
| | ХХХ*-с давсан хувь | 32.0 | 32.0 | 90.0 | 68.0 | 92.0 | - | 90.0 | 32.0 | 97.0 | 84.0 | 84.0 | 100.0 | - | 100.0 | 100.0 |
| | Хэмжилтийн тоо | 31 | 31 | 31 | 31 | 26 | - | 29 | 31 | 31 | 31 | 31 | 30 | - | 30 | 18 |
| Тоос $PM_{2.5}$ | Дундаж | - | 0.048 | 0.064 | 0.033 | - | - | - | - | 0.063 | 0.068 | 0.085 | 0.058 | - | 0.074 | - |
| | Хамгийн их | - | 0.102 | 0.120 | 0.068 | - | - | - | - | 0.088 | 0.108 | 0.172 | 0.109 | - | 0.137 | - |
| | ХХХ*-с давсан хувь | - | 39.0 | 68.0 | 10.0 | - | - | - | - | 74.0 | 81.0 | 90.0 | 60.0 | - | 77.0 | - |
| | Хэмжилтийн тоо | - | 31 | 31 | 31 | - | - | - | - | 31 | 31 | 31 | 30 | - | 30 | - |
| Озон O3** | Дундаж | 0.029 | - | 0.009 | 0.019 | 0.026 | - | - | 0.030 | 0.048 | - | - | - | - | - | - |
| | Хамгийн их | 0.050 | - | 0.017 | 0.034 | 0.055 | - | - | 0.052 | 0.079 | - | - | - | - | - | - |
| | ХХХ*-с давсан хувь | 0.0 | - | 0.0 | 0.0 | 0.0 | - | - | 0.0 | 0.0 | - | - | - | - | - | - |
| | Хэмжилтийн тоо | 77 | - | 93 | 93 | 79 | - | - | 93 | 93 | - | - | - | - | - | - |

** - Хүлцэх хэм хэмжээ,* ***- CO, O3 -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.*

# ГЭМТ ХЭРЭГ

2019 оны эхний 3 сард дүүргийн хэмжээнд нийт 1160 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 288 хэргээр (19.9%) буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 16.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.2 пунктээр өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 30.4 хувийг хулгайн, 18.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 25.8 хувийг залилан, 5.4 хувийг дээрмийн, 2.8 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 2.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 0.8 хувийг хүчин, 13.4 хувийг бусад, 0.7 хувийг хүнийг алах, 0.2 хувийг олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, жил бүрийн эхний 3 сард

| | | Гэмт хэргийн тоо | | | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2017 I-III | 2018 I-III | 2019 I-III | Тоо | Хувь |
| Нийт гэмт хэрэг | | 746 | 1 448 | 1 160 | -288 | 80.1 |
| Гэмт хэргийн төрөлү | Хүнийг алах | 4 | 2 | 8 | -6 | 4* |
| | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 10 | 26 | 32 | -6 | 123.1 |
| | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 257 | 323 | 210 | -113 | 65.0 |
| | Хүчиндэх | 5 | 14 | 10 | -4 | 71.4 |
| | Хулгайлах | 163 | 571 | 353 | -218 | 61.8 |
| | Дээрэмдэх | 23 | 107 | 63 | -44 | 58.9 |
| | Залилах | 109 | 244 | 299 | 55 | 122.5 |
| | ХАБТХАЖЭ[6] | 27 | 23 | 28 | 5 | 121.7 |
| | Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | - | - | 2 | 2 | - |
| | Булаалт | 4 | - | - | - | - |
| | Бусад | 144 | 138 | 155 | 17 | 112.3 |

*дахин их

2019 оны эхний 3 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 1025 нь (88.4%) хөнгөн хэрэг, 135 нь (11.6%) хүнд хэрэг байна. Мөн нийт бүртгэгдсэн 1160 гэмт хэргээс 637 нь (54.9%) цагдаагийн I хэлтэст, 523 нь (45.1%) цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн байна.

[6] Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг

Хүснэгт 13. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, хэлтсээр, 2019 оны эхний 3 сард

| Төрөл | | Дүүргийн дүн | Цагдаагийн I хэлтэс | Цагдаагийн II хэлтэс |
|---|---|---|---|---|
| Нийт гэмт хэрэг | | 1 160 | 637 | 523 |
| Хэргийн ангилал | Хөнгөн | 1 025 | 556 | 469 |
| | Хүнд | 135 | 81 | 54 |
| Гэмт хэргийн төрөл | Хүнийг алах | 8 | 4 | 4 |
| | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 32 | 20 | 12 |
| | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 210 | 142 | 68 |
| | Хүчиндэх | 10 | 6 | 4 |
| | Хулгайлах | 353 | 156 | 197 |
| | Дээрэмдэх | 63 | 37 | 26 |
| | Залилах | 299 | 177 | 122 |
| | ХАБТХАЖЭ | 28 | 16 | 12 |
| | Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | 2 | - | 2 |
| | Бусад | 155 | 79 | 76 |

Зураг 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор, жил бүрийн эхний 3 сард



Хүснэгт 14. Гэмт хэргийн тоо, хороо, төрлөөр

| Хороо | Нийт | Хүн амь | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | Хүчин | Хулгай | Дээрэм | Залилан | ХАБТХАЖЭ | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | 1 160 | 8 | 32 | 210 | 10 | 353 | 63 | 299 | 28 | 157 |
| 1-р хороо | 63 | 1 | - | 8 | - | 12 | 2 | 27 | 1 | 12 |
| 2-р хороо | 87 | 1 | 3 | 8 | 1 | 10 | 5 | 49 | 4 | 6 |
| 3-р хороо | 74 | - | 3 | 19 | 1 | 14 | - | 21 | 2 | 14 |
| 4-р хороо | 48 | - | - | 4 | - | 16 | 2 | 15 | 1 | 10 |
| 5-р хороо | 67 | - | 1 | 13 | - | 15 | 1 | 24 | 1 | 12 |
| 6-р хороо | 72 | 1 | 3 | 9 | - | 20 | 9 | 14 | 1 | 15 |
| 7-р хороо | 60 | 1 | 2 | 8 | 1 | 23 | 4 | 14 | 3 | 4 |
| 8-р хороо | 51 | - | - | 9 | 1 | 20 | 4 | 13 | 1 | 3 |
| 9-р хороо | 29 | - | 1 | 4 | - | 17 | 1 | 3 | 1 | 2 |
| 10-р хороо | 33 | 1 | 2 | 7 | 2 | 13 | - | 5 | - | 3 |
| 11-р хороо | 50 | 1 | 5 | 10 | - | 20 | 1 | 5 | 1 | 7 |
| 12-р хороо | 56 | - | 1 | 11 | 2 | 17 | 4 | 13 | 2 | 6 |
| 13-р хороо | 48 | - | - | 3 | - | 17 | 2 | 12 | 2 | 12 |
| 14-р хороо | 56 | 1 | 1 | 18 | - | 19 | 3 | 12 | 1 | 1 |
| 15-р хороо | 22 | - | - | 2 | - | 5 | 3 | 8 | - | 4 |
| 16-р хороо | 52 | - | 2 | 14 | - | 11 | 3 | 9 | 3 | 10 |
| 17-р хороо | 40 | - | 1 | 6 | - | 11 | 5 | 11 | 1 | 5 |
| 18-р хороо | 58 | - | 3 | 21 | 1 | 10 | 7 | 9 | - | 7 |
| 19-р хороо | 31 | - | - | 14 | 1 | 3 | 2 | 7 | - | 4 |
| 20-р хороо | 103 | 1 | 2 | 10 | - | 49 | 3 | 21 | 2 | 15 |
| 21-р хороо | 12 | - | 1 | 1 | - | 7 | - | 1 | - | 2 |
| 22-р хороо | 26 | - | - | 8 | - | 13 | 2 | 1 | - | 2 |
| 23-р хороо | 22 | - | 1 | 3 | - | 11 | - | 5 | 1 | 1 |

Эх үүсвэр: БГД дэх Цагдаагийн 1, 2-р хэлтсийн мэдээ

## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого 2019 оны эхний 3 сард байдлаар 23 439.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 237.1 сая төгрөгөөр (1.0%)-аар буурсан байна. Төсвийн нийт орлогын 24.0 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 76.0 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна. Татварын бус орлогын дунд Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг хамгийн өндөр буюу 16878.7 сая төгрөгийг (94.8%) эзэлж байна.

Хүснэгт 15. Төсвийн орлого, сая төгрөгөөр, 2019 оны эхний 3 сард

| Үзүүлэлт | 2019 I-III | | |
|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | % |
| Нийт орлого | 23 677.0 | 23 439.9 | 99.0 |
| 1.Татварын орлого | 5 942.8 | 5 635.5 | 94.8 |
| 1.1 Орлогын албан татвар | 4 865.0 | 5 036.6 | 103.5 |
| Хувь хүний орлогын албан татвар | 4 865.0 | 5 036.6 | 103.5 |
| Үйл ажиллагааны орлого | 375.0 | 483.0 | 128.8 |
| Хөрөнгийн орлого | 1 830.0 | 2 795.7 | 152.8 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 960.0 | 435.6 | 45.4 |
| Шууд бус орлого | 1 700.0 | 1 322.3 | 77.8 |
| 1.2 Хөрөнгийн татвар | 24.0 | 9.5 | 39.6 |
| Бууны албан татвар | 24.0 | 9.5 | 39.6 |
| 1.3 Бусад татвар, төлбөр, хураамж | 1 053.8 | 589.4 | 55.9 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 363.8 | 326.1 | 89.6 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 690.0 | 262.6 | 38.1 |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 0.0 | 0.1 | - |
| Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 0.0 | 0.6 | - |
| 2. Татварын бус орлого | 17 734.2 | 17 804.4 | 100.4 |
| 2.1 Нийтлэг татварын бус орлого | 777.8 | 925.7 | 119.0 |
| 2.1.1 Торгуулийн орлого | 600.0 | 762.5 | 127.1 |
| 2.1.2 Төсөвт байгууллагын өөрийн орлого | 177.8 | 161.1 | 90.6 |
| 2.1.3 Бусад орлого | - | 2.1 | - |
| 2.2 Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 16 956.4 | 16 878.7 | 99.5 |
| 2.2.1 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 16 785.4 | 16 785.4 | 100.0 |
| 2.2.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 171.0 | 93.3 | 54.6 |

Хүснэгт 16. Төсвийн зарлага, сая төгрөгөөр, 2019 оны эхний 3 сард

| Үзүүлэлт | 2019 I-III | | |
|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | % |
| Нийт зарлага | 24 064.2 | 19 786.6 | 82.2 |
| Урсгал зардал | 23 085.9 | 19 786.6 | 85.7 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 20 142.1 | 17 411.0 | 86.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 11 628.1 | 10 607.4 | 91.2 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1 490.1 | 1 360.9 | 91.3 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1 204.5 | 1 034.1 | 85.9 |
| Хангамж бараа материалын зардал | 838.0 | 760.2 | 90.7 |
| Нормативт зардал | 1 598.3 | 972.4 | 60.8 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 119.2 | 40.5 | 34.0 |
| Томилолт, зочны зардал | 42.5 | 15.4 | 36.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 991.6 | 720.1 | 72.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 2 229.8 | 1 900.0 | 85.2 |
| Татаас | 1 648.5 | 1 439.5 | 87.3 |
| Урсгал шилжүүлэг | 1 295.3 | 936.1 | 72.3 |
| Хөрөнгийн зардал | 978.3 | - | - |

Эх үүсвэр: Санхүү төрийн сангийн хэлтэс

Төсвийн нийт зарлага 2019 эхний 3 сард 19786.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 4277.6 сая төгрөгөөр (17.8%) буурсан байна. Төсвийн нийт зарлагын дунд урсгал зардал хамгийн өндөр буюу 88.0 хувийг эзэлж байна.

Зураг 12. Төсвийн орлого, зарлага, сая төгрөгөөр, 2019 оны эхний 3 сард



Хүснэгт 17. Татварын орлого, мян.төг, 2019 оны эхний 3 сард

| Үзүүлэлт | 2019 I-III | | |
|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | % |
| НИЙТ ОРЛОГО | 48 099.4 | 48  096.0 | 99.9 |
| А. Дүүргийн төсвийн орлого | 6 542.8 | 6 763.5 | 103.3 |
| Газар эзэмших, ашиглах эрх борлуулсны орлого | - | -4.7 | - |
| Галт зэвсгийн албан татвар | 24.0 | 9.5 | 39.6 |
| Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого | 1 830.0 | 2 795.2 | 152.7 |
| Иргэний үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар | 960.0 | 436.6 | 45.5 |
| Нэр заагдаж ангилагдаагүй бусад орлого | - | 3.3 | - |
| Татварын алдангийн орлого | - | 257.0 | - |
| Татварын торгуулийн орлого | - | 426.4 | - |
| Татварын хүү, торгуулийн орлого | 600.0 | 97.8 | 16.3 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 363.8 | 368.2 | 101.2 |
| Хог, хаягдлын хураамж | 690.0 | 273.5 | 39.6 |
| Хувь хүний орлогын албан татвар | 375.0 | 487.9 | 130.1 |
| Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар | 1 700.0 | 1 612.8 | 94.9 |
| Б. Нийслэлийн төсвийн орлого | 22 070.9 | 18 144.4 | 82.2 |
| Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар | 2 537.9 | 1 504.8 | 59.3 |
| Зам ашигласны төлбөр | 1 105.5 | 718.6 | 65.0 |
| Үл хөдлөх хөрөнгийн татвар | 2 345.7 | 1 463.9 | 62.4 |
| Нийслэл хотын албан татвар | 411.7 | 300.0 | 72.9 |
| Ус ашигласны төлбөр | 290.3 | 199.5 | 68.7 |
| Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого | 15 379.8 | 13 957.6 | 90.8 |
| В. Улсын  төсвийн орлого | 19 485.7 | 23 188.1 | 119.0 |
| Автын агаарын бохирдлын төлбөр | 70.5 | 60.2 | 85.4 |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 6 976.0 | 9 227.0 | 132.3 |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | - | - | - |
| Дотоодын архины онцгой албан татвар | 312.6 | 370.8 | 118.6 |
| Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ | 12 062.5 | 13 066.0 | 108.3 |
| Дотоодын пивоны онцгой албан татвар | 64.1 | 73.0 | 114.1 |
| Дотоодын спиртийн онцгой албан татвар | - | 13.3 | - |
| Органик уусгагчийн агаарын бохирдлын төлбөр | | | - |
| Оршин  суугч бус этгээдээс суутгасан НӨАТ | - | 377.8 | |

*дахин их

Эх үүсвэр: БГД-ийн Татварын хэлтсийн мэдээ

# ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2019 оны 3 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2018 оны эцэстэй харьцуулахад 1.5 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувь, 2 дугаар сартай харьцуулахад 0.8 хувиар тус тус өссөн байна.

Зураг 13. Хэрэглээний үнийн индекс




